

Техникийн тодорхойлолт

Санал болгох бараа нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна. Хуулийн 26.8-д зааснаар эсхүл түүнтэй дүйцэх" гэсэн тодотгол хэрэглэсэн техникийн тодорхойлолтод өөр бараа санал болгосон оролцогч техникийн тодорхойлолтод заасантай дүйцэх болохыг ТШЗ 20.2-т заасан баримт бичгээр нотолсон бол техникийн тодорхойлолтыг хангасан гэж үзнэ.

Барааны нэр: Нүүрс

№	Захиалагчийн техникийн тодорхойлолт (Тухайн барааны үзүүлэлт тус бүрийг дор жагсааж бичих ба хэрвээ чанарын баталгаат хугацаа шаардах бол бичнэ үү.)	Санал болгож буй техникийн тодорхойлолт (Зөвхөн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг бичнэ үү.)	Тайлбар (дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулгыг хавсаргана)
1	Нийлүүлэгч нь хамгийн бага сайн чанарын хатуу түлшийг худалдан авагч талд жилийн туршид тасалдуулалгүй олгох.		
2	Нийлүүлэх түлш нь стандартын дагуу үйлдвэрлэгдсэн болон түүнтэй дүйцэхүйц чанар стандартыг хангасан байна.Өөр гарал үүсэлтэй бараа нийлүүлэх тохиолдолд тухайн барааг үйлдвэрлэсэн стандарт нь Монгол улсын MNS 216:2006. MNS 217:2006 стандартыг хангаж байгааг нотолсон бичиг заавал ирүүлнэ.		
3	Нийлүүлэх бараа нь үйлдвэрийн болон бусад шалгалт, туршилтын жагсаалтыг холбогдох мэдээллийн хамт ирүүлнэ.Холбогдох стандартад нийцэж байгаа болон түүнээс илүүгээр хангаж байгааг харуулсан дагалдах бичгүүдийг заавал хавсаргана.		

Техникийн тодорхойлолт

Барааны нэр: Нүүрс

№	Захиалагчийн техникийн тодорхойлолт (Тухайн барааны үзүүлэлт тус бүрийг дор жагсааж бичих ба хэрвээ чанарын баталгаат хугацаа шаардах бол бичнэ үү.)	Санал болгож буй техникийн тодорхойлолт (Зөвхөн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг бичнэ үү.)	Тайлбар (дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулгыг хавсаргана)
1	Ангилсан нүүрс	Бид Монгол Улсын эрчим хүчний нүүрсний 60 хувийг дангаараа хангадаг Багануур ХК-тай 2021 оноос хойш нүүрс худалдан авах ажиллагааг зохион байгуулж, захиалагч байгууллагууддаа нүүрс тээвэрлэн нийлүүлдэг. Манай байгууллагын нийлүүлэх нүүрс нь Багануурын уурхайн нүүрс болох Б2 хүрэн нүүрс бөгөөд 0.38%-ийн хүхэр, 17.5%-ийн үнслэг, 3360 ккал/кг илчлэгтэй нүүрс бөгөөд энэ нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн дулаан хангамжийн явцад ямар нэгэн доголдол үүсгэдэггүй бөгөөд дулааны цахилгаан станц, үйлдвэр, албан байгууллага болон ахуйн хэрэгцээнд зориулсан юм. Нийлүүлсэн нүүрсэн дэх 25мм-ээс дээш хэмжээний шавар чулуулгийн хольц жингийн 3%-иас хэтрэхгүй байна. Монгол Улсын болон олон улсын шаардлагад нийцсэн аргаар олборлож буй нүүрсийг нийлүүлнэ. Чанарын нүүрсийг нийлүүлэх явцад дагалдах баримт бичгийг тухай бүр нь захиалагчид хүргүүлнэ.	“Багануур”-ын уурхайн нүүрсний техникийн ерөнхий шаардлага MNS 3818:2001 Монгол Улсын стандарт хэмжилзүйн төвөөс гаргасан стандартыг хавсаргав.

[Үнэлгээний хороо худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/д нийтэлсэн техникийн тодорхойлолтын жишиг нөхцөл, стандарт, загварыг баримтлан техникийн тодорхойлолтыг боловсруулна.]

Лхагвадорж ХУДАН

Биг мүди интернэшнл ХХК

Захиргаа

Гүйцэтгэх захирал

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Код 73.040

“Багануур”-ын уурхайн нүүрс. Техникийн шаардлага Baganuur's coals. Technical requirements	MNS 3818 : 2001
	MNS 3818-91 –ын оронд

Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төвийн Зөвлөлийн 2001 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 57 дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандарт 2001 оны 11 дүгээр сарын 01-нээс эхлэн хүчинтэй.

Энэ стандартын норматив шаардлагыг заавал мөрдөнө.

1. Хамрах хүрээ

Энэ стандартаар “Багануур”-ын уурхайн хүрэн нүүрсний техникийн шаардлагыг тогтооно.

2. Техникийн шаардлага

2.1. “Багануур”-ын уурхайн хүрэн нүүрсний техникийн шаардлага 1 ба 2-р хүснэгтэд заасантай тохирч байна.

1-р хүснэгт

Нүүрсний төрөл	Үнслэг хувиар ихгүй A'	Чийглэг хувиар ихгүй W'	Нийт хүхрийн хэмжээ хувиар ихгүй S ^d	Дэгдэмхий бодис хувиар V	Илчлэг, Q _i	
					Ккал/кг	Мж/кг
Хүрэн нүүрс Б2	17.5	37.5	0.38	44.8	3360	14

2-р хүснэгт

Нүүрсний төрөл	Битум A, %	Органик бодисын элементүүдийн найрлага, %					Гумины хүчлийн агуулга, %	
		C ^a	H ^a	C ^{daf}	H ^{daf}	(O+H+S) ^{daf}	HA ^a	HA ^{daf}
Хүрэн нүүрс Б2	5.2	62.40	4.6	72.5	4.75	5.71	14	15

2.2. “Багануур”-ын уурхайн хүрэн нүүрсний бутармагийн хэмжээ 3-р хүснэгтэд заасан үзүүлэлттэй тохирч байна.

3-р хүснэгт

Хэрэглээний зориулалт	Тэмдэглэгээ	Нүүрсний бутармагийн хэмжээ, мм
Дулааны цахилгаан станцад	X	0-100, 0-300
Үйлдвэр албан байгууллага, ахуйн хэрэгцээнд	X	0-300

2.3. Олборлосон нүүрсний бутармагийг MNS-2718-79-ийн дагуу ангилна.

2.4. Нийлүүлсэн нүүрсэн дэх 25мм-ээс дээш хэмжээний шавар, чулуулгийн хольц жингийн 3%-иас хэтрэхгүй байна.

MNS 3818 :2001

2.5. 25мм-ээс дээш хэмжээний шавар, чулуулгийн хольц дээрх заалтаас хэтэрвэл, хэтэрсэн хувь тутамд жингийн хорогдол хийнэ.

2.6. Исэлдэж илчлэг чанараа алдсан нүүрсийг хэрэглэгчид нийлүүлэхийг хориглоно.

2.7. Нүүрсний давхаргуудын гарш орчмын исэлдлийн бүс дэх 25 мкР/цаг- аас хэтэрсэн үзүүлэлт бүхий цацраг идэвхижилтэй нүүрсийг хэрэглэгчид нийлүүлэхийг хориглоно.

3. Шалгах, хүлээн авах, турших арга

3.1. Нүүрсийг хэрэглэгчид нийлүүлэхдээ энэ стандарт, "MNS-894-82 Нүүрсийг чанараар хүлээн авах журам" стандартыг баримтлана.

3.2. Нүүрснээс дээж авах, шинжилгээ хийхдээ дараахь стандартуудыг мөрдөнө. Үүнд: Хүрэн, чулуун нүүрс, антрацит ба занар

- ♣ Хүрэн чулуун нүүрс, антрацит ба шатах занараас лабораторийн туршилтанд зориулж дээж авах ба боловсруулах арга MNS 895-80
- ♣ Ашиглалтын давхаргаас дээж авах арга MNS 2732-79
- ♣ Цооногоор товарын дээж авах ба лабораторийн туршилтад зориулж тэдгээрийг боловсруулах MNS 2719-79
- ♣ Түлшийг шатаахад гарах илчлэгийн хэмжээг тодорхойлох арга MNS 669-82
- ♣ Дэгдэмхий бодисын гарцыг тодорхойлох арга MNS 654-79
- ♣ Үнслэг тодорхойлох арга MNS 652-79
- ♣ Чийглэг тодорхойлох арга MNS 655-79
- ♣ Азотыг кьелдагийн аргаар тодорхойлох MNS 653-83
- ♣ Хүхрийн хэмжээг тодорхойлох арга MNS 656-79
- ♣ Нүүрстөрөгч, устөрөгч, хүчилтөрөгчийг тодорхойлох арга MNS 668-83
- ♣ Шигшүүрийн шинжилгээ хийх арга MNS 1620-85
- ♣ Давхрагаас дээж авах арга MNS 667-80
- ♣ Үзэгдэх чулуулаг ба жижгэрсэн ширхгийн агуулгыг тодорхойлох хяналтын дээжийг турших арга MNS 893-80
- ♣ Вагонд нүүрс ачих техникийн шаардлага MNS 1745-73

ТӨГСӨВ